

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн
2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/05-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Сүхбаатар сум
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
Утас: 70363040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Батмөнх
Утас: 70363036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
Аудитор: Д.Чулуунцэцэг
Утас: 70362442 Цахим хаяг: Chuluuntsetsegd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

Аудитын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	
3.4.1 Мөнгөн хөрөнгө	13
3.4.4 Үндсэн хөрөнгө	15
3.4.5 Өр төлбөр	16
3.4.6 Засгийн газрын хувь оролцоо	16
3.4.8 Зардлын данс	16
4. Аудитын тайлан	
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	21
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	22
4.5.1 Завсрын аудитын талаар	22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	23
5. Аудитын илрүүлэлт	
5.1 Төлбөрийн акт	24
5.2 Албан шаардлага	24
5.3 Зөвлөмж	26
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	27-26

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОАЖГ	Байгаль, орчин аялал жуулчлалын газар
БОАЖЯ	Байгаль, орчин аялал жуулчлалын яам
ГХУССЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУЗЗНДНТУ	Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэр түүний удирдлагын тухай хууль
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хууль
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХС	Хоршоог хөгжүүлэх сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГХУСАХ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ЭМТ	Эрүүл мэндийн төв



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023-03-25 № СЭА-2023/05-НА-СТА-ТТЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Зүүнбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Зүүнбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлын онцолсон хэсэг

Зүүнбүрэн сумын ТТЗ нь 2022 оны төсвийн орлогын төлөвлөгөөг 37,540.4 мянган төгрөгөөр буюу 8.0 хувиар тасалсан бөгөөд төсвийн зарлагын гүйцэтгэл 76.9 хувьтай тайлагнагдан, батлагдсан төсвийг 23.1 хувиар хэмнэсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, ЭМТ, соёлын төв нь тус тусын яамдын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяанд шилжсэн болон ЗДТГ-т бүртгэлтэй халаалтын уурын зуух, дулааны шугам зэрэг хөрөнгийг аймгийн ИТХ-ын

2022 оны 91 дүгээр тогтоолоор Илдэн бүрэн ОНӨААТҮГ-т шилжүүлснээс сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хөрөнгө, бараа материалын үлдэгдэл буурсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд танилцуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	574,378.4	539,904.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	197,151.2	356,040.5
33	АВЛАГА	115,524.3	139,448.4
35	БАРАА МАТЕРИАЛ	261,702.9	44,415.2
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,965,145.6	1,881,691.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,965,145.6	1,881,691.9
39200	Биет хөрөнгө	5,870,991.8	1,865,974.1
39300	Биет бус хөрөнгө	94,153.8	15,717.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,539,524.0	2,421,596.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,697.7	4,778.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,697.7	4,778.1
41300	Өглөг	5,697.7	4,778.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,533,826.3	2,416,817.9
51	Засгийн газрын хувь оролцоо	6,533,826.3	2,416,817.9
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,797,431.6	297,811.3
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,797,431.6	297,811.3
51200	Хуримтлагдсан үр дүн	2,312,094.6	1,652,781.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,424,300.1	466,225.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,539,524.0	2,421,596.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,275,401.0	1,753,790.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	162,394.0	428,491.6
110	Орлогын албан татвар	44,955.4	189,029.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	44,955.4	189,029.4
113	Хөрөнгийн албан татвар	77,651.0	87,971.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	39,787.6	151,490.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	823,428.2	227,017.3
120	Нийтлэг татварын бус орлого	823,428.2	227,017.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,289,578.8	1,098,281.9
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,542,197.7	1,156,409.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,542,197.7	1,126,409.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,464,030.2	1,109,051.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,455,557.6	334,280.7

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	186,710.4	40,235.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	244,518.4	296,666.7
2104	Хангамж, бараа материалын зардал	63,013.8	44,135.8
2105	Нормативт зардал	146,761.4	231.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,487.2	40,864.3
2107	Томилолт, зочны зардал	1,739.3	5,079.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,812.8	27,088.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	306,429.4	320,469.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,078,167.5	17,358.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	29,999.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	733,203.4	597,381.7
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	70,205.3	4,721,096.4
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	662,998.1	-4,123,714.7

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,870,828.2	0.0	5,870,828.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,870,828.2	0.0	5,870,828.2
5	Тайлант үеийн үр дүн	662,998.1	0.0	662,998.1
7	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,533,826.3	0.0	6,533,826.3
9	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,533,826.3	0.0	6,533,826.3
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	6,706.3	0.0	6,706.3
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,540,532.6	0.0	6,540,532.6
15	Тайлант үеийн үр дүн	-4,123,714.7	0.0	-4,123,714.7
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,416,817.9	0.0	2,416,817.9

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН	3,537,705.5	1,600,241.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	162,394.0	428,491.6
110	Орлогын албан татвар	44,955.4	189,029.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	44,955.4	189,029.4
113	Хөрөнгийн албан татвар	77,651.0	87,971.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	39,787.6	151,490.3
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	9,870.3	61,837.8
1181	Газрын төлбөр	27,316.0	58,197.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	2,601.4	31,455.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	85,732.7	73,468.4
120	Нийтлэг татварын бус орлого	85,732.7	73,468.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,289,578.8	1,098,281.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,260,822.1	900,018.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,260,822.1	900,018.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,182,654.6	881,811.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,455,625.4	330,552.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	186,642.6	38,808.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	244,518.4	296,666.7
2104	Хангамж, бараа материалын зардал	53,382.8	45,852.5
2105	Нормативт зардал	140,866.1	1,290.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,478.0	45,137.9
2107	Томилолт, зочны зардал	1,739.3	4,926.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,940.8	30,485.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,461.2	88,092.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,078,167.5	18,206.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	276,883.4	700,223.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	97,622.4	461,334.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	97,622.4	461,334.2
2200	Дотоод эх үүсвэрээр	97,622.4	461,334.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-97,622.4	-461,334.2
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-37,000.4	-80,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	37000.4	80,000.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	142,260.7	158,889.2
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	54,890.6	197,151.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	197,151.2	356,040.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,469,555.10	1,129,581.28	339,973.82	76.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,016,243.10	890,425.36	125,817.74	87.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	997,357.20	873,067.33	124,289.37	87.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	370,210.30	330,552.41	39,657.89	89.29
210101	Үндсэн цалин	246,657.20	229,669.26	16,987.94	93.11
210102	Нэмэгдэл	62,943.70	43,761.58	19,182.12	69.52
210104	Урамшуулал	7,531.80	6,762.32	769.48	89.78
210105	Гэрээт ажлын хөлс	53,077.60	50,359.25	2,718.35	94.88
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,048.90	38,808.19	8,240.71	82.48
210201	Тэтгэврийн даатгал	32,066.10	26,999.47	5,066.63	84.2
210202	Тэтгэмжийн даатгал	3,751.40	3,177.70	573.70	84.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,978.70	2,485.99	492.71	83.46
210204	Ажилгүйдлийн даатгал	750.40	549.95	200.45	73.29
210205	Эрүүл мэндийн даатгал	7,502.30	5,595.08	1,907.22	74.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	335,750.20	296,666.69	39,083.51	88.36
210301	Гэрэл, цахилгаан	61,558.30	47,057.93	14,500.37	76.44
210302	Түлш, халаалт	264,164.70	239,723.96	24,440.74	90.75
210303	Цэвэр, бохир ус	10,027.20	9,884.80	142.40	98.58
2104	Хангамж, бараа материалын зардал	42,008.10	41,116.89	891.21	97.88
210401	Бичиг хэрэг	7,488.60	7,488.51	0.09	100
210402	Тээвэр, шатахуун	16,520.30	16,520.30	0.00	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,546.90	3,656.88	890.02	80.43
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,424.00	6,424.00	0.00	100
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,028.30	7,027.20	1.10	99.98
2105	Нормативт зардал	1,290.00	1,290.00	0.00	100
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,290.00	1,290.00	0.00	100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	54,739.70	50,157.58	4,582.12	91.63
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,954.70	8,954.70	0.00	100
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	572.20	0.00	572.20	0
210604	Урсгал засвар	45,212.80	41,202.88	4,009.92	91.13
2107	Томилолт, зочны зардал	6,926.30	4,926.90	1,999.40	71.13
210702	Дотоод албан томилолт	6,926.30	4,926.90	1,999.40	71.13
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,940.60	22,401.21	539.39	97.65
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,234.30	21,028.70	205.60	99.03
210803	Даатгалын үйлчилгээ	482.30	205.45	276.85	42.6

210804	Тээврийн хэрэгслийн татвар	735.30	733.36	1.94	99.74
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	262.10	209.00	53.10	79.74
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	46.90	45.00	1.90	95.95
210807	Газрын төлбөр	179.70	179.70	0.00	100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	116,443.10	87,147.46	29,295.64	74.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	115,656.70	86,872.96	28,783.74	75.11
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	786.40	274.50	511.90	34.91
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,885.90	17,358.04	1,527.86	16.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,885.90	17,358.04	1,527.86	16.41
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,827.80	300.00	1,527.80	16.41
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,878.10	16,878.04	0.06	100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	180.00	180.00	0.00	100
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	299,503.00	159,155.91	140,347.09	53.14
220001	Барилга байгууламж	134,503.00	119,731.91	14,771.09	89.02
222001	Тоног төхөөрөмж	145,000.00	29,424.00	115,576.00	20.29
223001	Бусад хөрөнгө	20,000.00	10,000.00	10,000.00	50
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	153,809.00	80,000.00	73,809.00	52.01
230001	Эргэж төлөгдөх зээл	153,809.00	80,000.00	73,809.00	52.01
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,469,555.10	1,242,291.91	227,263.19	84.54
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,208,533.40	1,173,603.54	34,929.86	97.11
320001	Орон нутгийн төсвөөс	1,075,093.10	1,040,163.24	34,929.86	97.11
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	133,440.30	133,440.30	0.00	100
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	261,021.70	68,688.37	192,333.33	26.32
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	97,232.00	68,688.37	28,543.63	70.64
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	163,789.70	0.00	163,789.70	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	66,758.27	-66,758.27	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	178,620.30	178,620.30	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1,653.00	60.00	1,593.00	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	7.00	2.00	5.00	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	126.00	29.00	97.00	
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	697.00	0.00	697.00	
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	529.00	0.00	529.00	
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	168.00	0.00	168.00	
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	126.00	29.00	97.00	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	360,560,508.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	64,896,587.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,258,839.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,735,656.00
210401	Бичиг хэрэг	645,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,973,056.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,087,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,084,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,084,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,439,183.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,439,183.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,637,748.69
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	49,637,748.69
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	49,637,748.69
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	295,663,921.00
2200	Дотоод эх үүсвэрээр	295,663,921.00
220001	Барилга байгууламж	193,019,488.00
221001	Их засвар	79,231,933.00
222001	Тоног төхөөрөмж	23,412,500.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	360,560,508.69
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	360,560,508.69
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,304,958.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	330,628,704.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	22,626,846.69

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Өрхийг дэмжсэн өсөлтийн бодлогыг хэрэгжүүлж, төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2020-2024, аймгийн болон сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах, үр дүнг тооцож, иргэд олон нийтэд мэдээлэх,
- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 192 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ”-г тогтоосон гэх мэт.

Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2020-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдэж санхүүгийн тайлангийн тэмдэглэл, илтгэх хуудас тодруулга тайлан бичигдээгүй, шилэн дансны хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй, төсөвт байгууллагын үйл ажиллагаанд дотоодын хяналтыг хэрэгжүүлээгүй, ЭМТ нь эмийн эргэлтийн сангийн тооцоог бодоогүй зэрэг зөрчил илрүүлэн дүгнэлт, зөвлөмж хүргүүлсэн байна.

ТТЗ-ийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө сул байна гэж дүгнэж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зүүнбүрэн ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Зүүнбүрэн сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан “Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах төсөвт байгууллагад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тус сумын төсөвт байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлог тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,069,245.8 мянган төгрөгөөр буюу 62.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	197,151.20	356,040.50	158,889.30
Авлага	115,524.30	188,130.60	72,606.30
Бараа материал	261,702.90	44,415.20	- 217,287.70
Үндсэн хөрөнгө	5,965,145.60	1,881,691.90	- 4,083,453.70
Нийт хөрөнгө	6,539,524.00	2,470,278.20	- 4,069,245.80
Өр төлбөр	5,697.70	53,460.30	47,762.60
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6,533,826.30	2,416,817.90	- 4,117,008.40
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,539,524.00	2,470,278.20	- 4,069,245.80

Эх сурвалж: Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансанд бөгөөд өөрчлөлтийг тус бүрээр нь тайлбарлан харуулсан болно.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 356,040.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 158,889.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	197,151.20	356,040.50	158,889.30
Төгрөг	197,151.20	356,040.50	158,889.30

Төрийн сангийн харилцах	197,151.20	356,040.50	158,889.30
Дүн	197,151.20	356,040.50	158,889.30

Эх сурвалж: Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд орон нутгийн ерөнхий орлогын 177,420.2 мянган төгрөг, ОНХС-ийн 133,275.0 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн 45,345.3 мянган төгрөг тус тус байршиж байна

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 188,130.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 72,606.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
			Өсөлт (+), Бууралт (-)
Татаас, санхүүжилтийн авлага		48,682.20	48,682.20
Хувь хүмүүсээс авах авлага/ХХС зээл хүү/	115,524.30	139,448.4	23,924.1
Дүн	115,524.30	188,130.60	72,606.30

Эх сурвалж: Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэлд ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн данснаас ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн хөрөнгө оруулалтын ажлын 29,500.0 мянган төгрөг, барьцаа хөрөнгийн 19,182.2 мянган төгрөг, хоршоог хөгжүүлэх сангаас олгосон зээлийн 139,448.4 мянган төгрөг бүртгэгдсэн байна.

Тайлант оны нийт авлагын эцсийн үлдэгдлийн 74.1 хувь буюу 139,448.4 мянган төгрөгийг хоршоог хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн авлага эзэлж байгаа бөгөөд тухайн онд шинээр 80,000.0 мянган төгрөгийн зээлийг 2 хоршоонд олгож авлагаар нэмж бүртгэсэн байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 10 иргэнийг шүүхэд хандан шийдвэрлүүлэн ШШГГ гүйцэтгэх ажиллагаа явуулж байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 44,415.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 217,287.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
			Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	37,263.50		-37,263.50
Эм боох материал	18,015.60		-18,015.60
Бичиг хэргийн материал	12,365.10	3,105.10	-9,260.00
Аж ахуйн материал	98,319.30	9,839.20	-88,480.10
Сэлбэг хэрэгсэл	1,752.0	620.00	-1,132.00
Барилгын засварын материал		512.00	512.00
Хүнсний материал	120.40		-120.40
Бусад хангамжийн материал	93,867.00	30,338.90	-63,528.10
Дүн	261,702.90	44,415.20	- 217,287.70

Эх сурвалж: Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

ТТЗ-ийн бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 217,287.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 99,623.2 мянган төгрөгийн материал худалдан авсан, 9,396.4 мянган төгрөгийн замын тэмдгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан болон 79,719.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 11,322.3 мянган төгрөгийн бараа материалыг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн, ЕБС, ЭМТ, Соёлын төв, цэцэрлэгийн 235,265.1 мянган төгрөгийн бараа материалыг холбогдох яаманд үнэ төлбөргүй шилжүүлсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- ЗДТГ нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр төлбөрийн цахим баримтаар баталгаажуагүй **2738.7** мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэсэн.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 6,856,269.8 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 2,347,653.9 мянган төгрөг болж, 4,508,615.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	4,902,570.90	1,124,046.80	-3,778,524.1
Авто-тээврийн хэрэгсэл	284,079.50	119,704.60	-164,374.90
Машин тоног төхөөрөмж(компьютер)	437,077.60	70,400.70	-366,676.90
Тавилга, аж ахуйн эд хогшил	206,472.00	19,417.20	-187,054.80
Зам, гүүрийн байгууламж	250,104.90	292,870.40	42,765.50
Бусад үндсэн хөрөнгө	638,026.90	705,496.40	67,469.5
Ном	43,784.20	-	-43,784.20
Программ хангамж	500.00	-	-500.00
Бусад биет бус хөрөнгө	93,653.80	15,717.80	-77,936.00
Дүн	6,856,269.80	2,347,653.90	4,508,615.9

/мянган төгрөгөөр/

Эх сурвалж: Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

ТТЗ-ийн үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 4,508,615.9 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 248,766.0 мянган төгрөгийн /аймгийн хөрөнгө оруулалтаар эрх нь шилжсэн 49,232.0 мянган төгрөгийн хайрган хучилттай зам, 193,019.4 мянган төгрөгийн гэрэлтүүлэг, ЗДТГ-т 6,514.6 мянган төгрөгийн принтер, ПОЗ-ын машин, ус цэвэршүүлэгч/ хөрөнгө худалдан авсан, ОНХС-аас 168,417.5 мянган төгрөгийн /77,546.3 мянган төгрөгийн гудамжны гэрэлтүүлэг, 42,185.6 мянган төгрөгийн хайрган хучилттай зам, 29,424.0 мянган төгрөгийн Приус маркийн автомашин, 20,660.0 мянган төгрөгийн малчдын бүлгийн сургалтын байр, худаа/, Цагааннуур сумын ЗДТГ-аас 7,000.0 мянган төгрөгийн нам даралтын уурын зуухыг тус тус шилжүүлэн авсан болон Илдэнбүрэн ОНӨААТҮГ-т 611,269.4 мянган төгрөгийн бохирын машин, трактор, уурын зуух, дулааны төв шугам шилжүүлсэн, ЕБС, ЭМТ, Соёлын төв, цэцэрлэгийн 4,321,530.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг холбогдох яамдад тус тус үнэ төлбөргүй шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 53,460.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 47,762.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Бараа, үйлчилгээний зардлын өглөг	5,697.7		-5,697.7
НДШ-ийн өглөг		4,778.1	4,778.1
Байгууллагад төлөх өглөг		48,682.2	48,682.2
Дүн	5,697.70	53,460.30	47,762.60

Эх сурвалж: Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэлд ЗДТГ-ын 4,778.1 мянган төгрөгийн НДШ-ийн өглөг, ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн данснаас ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн хөрөнгө оруулалтын ажлын 29,500.0 мянган төгрөг, барьцаа хөрөнгийн 19,182.2 мянган төгрөгийн өглөг тайлагнагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Сумын ЗДТГ нь төсвийг зохистой удирдаж, ажил гүйлгээг тухай бүр хянаж баталгаажуулаагүйн улмаас НДШ-д 4,778.1 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,416,817.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,117,008.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,797,431.6	297,811.3	-1,499,620.3
Хуримтлагдсан үр дүн	2,312,094.6	1,652,781.5	-659,313.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,424,300.1	466,225.1	-1,958,075.0
Дүн	6,533,826.30	2,416,817.90	- 4,117,008.40

Эх сурвалж: Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо данс нийт 4,117,008.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд ЕБС, ЭМТ, Соёлын төв, цэцэрлэг зэрэг байгууллагууд нь санхүүгийн хаалтын тайлан гаргаж засгийн газрын санг бууруулан бүртгэсэнтэй холбоотой байна.

3.4.7 Зардлын данс

Зардлын данстай холбоотой 3,062.8 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

ЗДТГ :

- Нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас 968.0 мянган төгрөгийн үнэ бүхий биеийн тамирын хувцас худалдан авч, албан томилолтын зардлаас хувцасны хэмжээ өгөхөд 120.0 мянган төгрөг зарцуулсан зэрэг нийт 1,088.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан,

ИТХ :

- ИТХ нь ГХУС арга хэмжээний зардлаас Зөвлөлийн болон Засаг даргын захирамж, шийдвэргүйгээр 894.8 мянган төгрөгийн хяналтын камер худалдан авсан бөгөөд цагдаагийн өдөр тутмын үйл ажиллагаанд 1,080.0 мянган төгрөгийн шатаахууныг зориулалт бусаар зарцуулсан,

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт

Сумын ИТХ-ын 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор “Зүүнбүрэн сумын 2022 оны төсөв тодотгон батлах” тогтоолоор тайлант оны татварын болон татварын бус орлогыг 105,338.0 мянган төгрөгөөр бууруулан 470,812.0 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 433,271.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 8 хувиар тасалдуулсан байна.

Хүснэгт 8. Төсвийн орлогын гүйцэтгэл

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
			Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого ХХОАТ	9,000.00	12,733.45	3,733.45	141.80
Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын албан татвар	120,000.00	149,295.85	29,295.85	124.40
Хөрөнгийн орлого	24,000.00	23,180.10	- 819.90	96.60
Малын тоо толгойн албан татвар	88,868.00	81,795.88	- 7,072.12	92.00
Хөрөнгө борлуулсны орлого	6,000.00	3,820.00	- 2,180.00	63.70
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	9,000.00	5,486.02	- 3,513.98	60.90
Бууны албан татвар	1,100.00	690.00	- 410.00	62.70
Улсын тэмдэгтийн хураамж	1,400.00	1,437.60	37.60	102.60
Түгээмэл тархацтай АМ ашигласны төлбөр	104,145.00	53,406.23	- 50,738.77	51.30
Хог хаягдал үйлчилгээ	6,000.00	6,994.00	994.00	116.60
Газрын төлбөр	24,125.00	25,642.51	1,517.51	106.20
Газрын дуудлага худалдаа	44,000.00	32,554.51	- 11,445.49	73.90
Ойн нөөц ашигласны төлбөр	-	22,654.60	22,654.60	
Ус рашааны төлбөр	1,000.00	5,044.69	4,044.69	504.50
Байгалийн ургамал ашигласны төлбөр	2,000.00	3,756.14	1,756.14	187.80

Бусад орлого	22,674.00	980.00	- 21,694.00	4.30
Торгуулийн орлого	7,500.00	3,800.00	- 3,700.00	50.70
Дүн	470,812.00	433,271.59	- 37,540.41	92.00

Эх сурвалж: Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогын төлөвлөгөө тасрахад түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлого 50,738.7 мянган төгрөгөөр, газрын дуудлага худалдааны орлого 11,445.5 мянган төгрөгөөр тасарсан нь голлон нөлөөлсөн байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 1,867,910.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2021 оны 25 дугаар тогтоолоор төсвийн орлогыг 576,150.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 7,232.0 мянган төгрөг, ерөнхий орлогын дансны эхний үлдэгдлээс 21,748.3 мянган төгрөг, ОНХС-ийн оны эхний үлдэгдлээс 77,194.4 мянган төгрөг, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 690,331.1 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 133,440.3 мянган төгрөг, СХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 154,847.0 мянган төгрөг зэрэг нийт 1,660,943.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 55 дугаар тогтоолоор аймгийн 2022 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан сумын ИТХ-ын 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор татварын болон татварын бус орлогыг **105,338.0** мянган төгрөгөөр бууруулан 470,812.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 7,232.0 мянган төгрөг, ОНХС-ийн оны эхний үлдэгдлээс 98,942.7 мянган төгрөг, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг **86,050.0** мянган төгрөгөөр бууруулан 604,281.1 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 133,440.3 мянган төгрөг, СХС-ийн зээлийн эргэн төлөлт 154,847.0 мянган төгрөг зэрэг нийт **1,469,555.1** мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр эцэслэн баталж, орлого эх үүсвэр болон зардлыг тус бүр **191,388.0** мянган төгрөгөөр бууруулж, тодотгосон байна. Үүнд:

- ИТХ-д 82,906.9 мянган төгрөг,
- ЗДТГ-д 579,666.7 мянган төгрөг,
- Улсын төсөвт байгууллагуудын орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх тогтмол зардалд 352,621.5 мянган төгрөг,
- ОНХС-д 299,503.0 мянган төгрөг,
- СХС-д 154,857.0 мянган төгрөг,

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр аймгаас авах санхүүгийн дэмжлэг 604,281.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 433,271.6 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас 133,440.3 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 7,296.0 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн

зээлийн эргэн төлөлт 61,392.4 мянган төгрөг зэрэг нийт **1,239,681.4** мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **1,129,581.3** мянган төгрөг буюу **76.9** хувьтай тайлагнагдсан нь хоршоог хөгжүүлэх сангаас төлөвлөсөн хэмжээгээр зээл олгоогүй, ТШЗ-д орон нутгийн төсвөөс олгох тогтмол зардлыг гүйцэтгэлээр санхүүжүүлсэн, харьяа байгууллагуудын төсвийн хэмнэлт зэргээс шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал 47,898.6 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 39,083.5 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 891.2 мянган төгрөгөөр, томилолтын зардал 1,999.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 29,295.6 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийн зардал 1,527.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдэж, 70,347.1 мянган төгрөгийн хөрөнгийн зардал зарцуулагдаагүй бөгөөд 73,809.0 мянган төгрөгийн хоршоо хөгжүүлэх сангийн зээл олгогдоогүй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчдаас 330,628.7 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 7,305.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 22,626.8 мянган төгрөг зэрэг нийт **360,560.5** мянган төгрөгийн нэмэлт орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж, бараа материалын зардалд 4,735.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 8,084.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 2,439.2 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 295,663.9 мянган төгрөг зэрэг нийт 310,922.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Зүүнбүрэн ТТЗ-ийн сумын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд албан хаагчдын улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тогтмол олгож байх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Чулуунцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 1/45 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4,275,401.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу **42,754.0** мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант оны хийгдсэн бүтцийн өөрчлөлтөөс шалтгаалан ЕБС, ЭМТ, Соёлын төв, цэцэрлэг зэрэг байгууллагуудын санхүүгийн тайлан тус тусын яамны төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардал болох 1,156,409.1 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон **11,564.1** мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн "Үүрэг чиглэл өгөх тухай" 01/633 дугаар албан бичгийн хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах, батлагдсан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, өр авлага үүсгэхгүй ажиллах, засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, ТБОНӨХБАУХА тухай хууль болон босго үнийн журмыг мөрдөн ажиллах, аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах гэх мэт нийт 18 төрлийн чиглэлийг хүргүүлсэн байна.

санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд албан хаагчдын улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тогтмол олгож байх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Чулуунцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Зүүнбүрэн сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 1/45 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4,275,401.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу **42,754.0** мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант оны хийгдсэн бүтцийн өөрчлөлтөөс шалтгаалан ЕБС, ЭМТ, Соёлын төв, цэцэрлэг зэрэг байгууллагуудын санхүүгийн тайлан тус тусын яамны төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардал болох 1,156,409.1 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон **11,564.1** мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн "Үүрэг чиглэл өгөх тухай" 01/633 дугаар албан бичгийн хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах, батлагдсан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, өр авлага үүсгэхгүй ажиллах, засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, ТБОНӨХБАУХА тухай хууль болон босго үнийн журмыг мөрдөн ажиллах, аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах гэх мэт нийт 18 төрлийн чиглэлийг хүргүүлсэн байна.

Үүнээс Зүүнбүрэн сумын ТТЗ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- Байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг хэмнэх зорилгоор цахилгааны тоолуурыг шинэчилсэн,
- Албан томилолт, шатахууны зардлыг хэмнэх зорилгоор ажилтнуудын сургалт, уулзалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан,
- Бичиг хэргийн зардлыг хэмнэх зорилгоор дотоод сүлжээ ашиглаж баримт бичгийг боловсруулсан

Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 47,898.6 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 39,083.5 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 891.2 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 1,999.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 29,295.6 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийн зардлыг 1,527.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэж, нийт **120,696.2** мянган төгрөгийн төсвийн хэмнэлтийг бий болгосон байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүснэгт 10. Шилэн дансны мэдээлэл

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
1	ТТЗ	155	152	3	-
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	151	149	2	-
3	Засаг даргын Тамгын газар	151	151	-	-
	Нийт дүн	457	452	5	

ТТЗ-ийн түвшинд нийт давхардсан тоогоор мэдээлбэл зохих 457 мэдээллээс 452 мэдээллийг хугацаанд нь 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Сумын ЗДТГ:

1.1. Илрүүлэлт: ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн Зүүнбүрэн сумын шинэ суурьшлын бүсийн гадна цахилгаан хангамжийн ажлын зураг төслийг Ариун мөнхийн гэрэл ХХК-аар гүйцэтгүүлсэн боловч зураг төсөвт тусгагдсан **648.3** мянган төгрөгийн зохиогчийн хяналтын гэрээг байгуулаагүй, ажлын үе шат бүрт зохиогчийн хяналт хийлгээгүй, дүгнэлт гаргуулж ажиллаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5 дугаар зүйлийн “Ил тод байдал, хяналт, тайлагналт, үр дүн”-ын 5.2.3 дахь “Захиалагч нь барилга байгууламжийн ажлын үе шат бүрт зохиогчоор хяналт тавиулж, дүгнэлт гаргуулна.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2. Шийдвэрлэсэн нь: Ажлын үе шат бүрт зохиогчийн хяналтыг хийлгэж, дүгнэлт гаргуулан ажиллах зөвлөмж өгөв.

2.1. Илрүүлэлт: Зүүнбүрэн сумын шинэ суурьшлын бүсийн гадна цахилгаан хангамжийн ажлын магадалшгүй ажлын зардлын **1,293.6** сая төгрөгийг магадалшгүй ажлын төсөв, гүйцэтгэсэн ажлын тайлангүйгээр олгосон байгаа Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.17 дахь “Магадалшгүй ажлын зардлыг барилгын гүйцэтгэгч, захиалагч байгууллагууд харилцан тохиролцсон актын дагуу зураг төсөлд тусгагдаагүй ажлыг санхүүжүүлэхэд зарцуулах бөгөөд уг зардлыг хурлын тэмдэглэл, магадалшгүй ажлын төсөв, баримтжуулсан фото зураг болон гүйцэтгэлийг үндэслэн олгоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2 Шийдвэрлэсэн нь: Магадалшгүй ажлын санхүүжилтийг хурлын тэмдэглэл, магадалшгүй ажлын төсөв, гүйцэтгэлийн тайланг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж байх зөвлөмж өгөв.

3.1 Илрүүлэлт: ЗДТГ, ИТХ нь төрийн албан хаагчдын ажлын үр дүнг улирал бүр үнэлж, үр дүнгийн урамшуулал олгоогүй зөвхөн жилийн эцэст 1 удаа олгосон нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 1.3-д “Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.2 Шийдвэрлэсэн нь: Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үнэлэн үр дүнгийн мөнгөн урамшуулал олгож байх зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар

улирлын санхүүгийн тайланд аудит хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг илүү тооцож олгосон, албан томилолтын зардлыг давхардуулан олгосон, эм, оношлуурын тооцоог сар бүр тогтмол бодоогүйгээс орлого дутуу төвлөрүүлсэн зэрэг зөрчилд төлбөрийн акт тогтоогдож, төсвийг зохистой удирдаагүйгээс өр төлбөр үүсгэсэн, жолоочийн шатахууны тооцоог бодоогүй, албан үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн албан хаагчид хариуцлага тооцох зэрэг зөрчилд албан шаардлага хүргүүлж, төсвийг бодит тооцоо судалгаа, мэдээлэл дээр үндэслэн төлөвлөөгүй, бараа материалын ангиллыг зөв бүртгэж тайлагнаагүй, шилэн дансанд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулаагүй зэрэг зөрчилд зөвлөмж өгөгдсөнөөс бараа материалын худалдан авалтыг төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Хүснэгт 11 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	6	7,563.2	6	7,563.2	100.0
Албан шаардлага	9	46,572.7	9	46,572.7	100.0
Зөвлөмж	6	106,024.0	5	106,024.0	83.3
Нийт дүн	21	160,159.9	20	160,159.9	95.2

Өмнөх аудитаар өгсөн холбогдох хууль, тогтоомжийн дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан төсвийн хөрөнгөөр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан бөгөөд харин төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн сэдэвт аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн асфальтан замын ажлыг гүйцэтгэж буй Монгол ЛЗ гүүр ХХК-ны гэрээт

ажлыг тасалдуулахгүй ажиллуулах гэсэн чиглэлийн дагуу тус газраас төвлөрүүлэхээр төлөвлөсөн түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлого бүрэн төвлөрөөгүйгээс шалтгаалж төсвийн нийт орлогын төлөвлөгөөг 37,540.4 мянган төгрөгөөр тасалдуулсан байна. Дараагийн аудитаар тус компаниас төвлөрүүлбэл зохих орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэхийг авч үзэх нь зүйтэй юм.

3. ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд Монгол ЛЗ зам гүүр ХХК нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгааны төлбөрт **19,182.2** мянган төгрөгийг холбогдох баримт материал болон гэрээ байгуулалгүйгээр барьцаа хөрөнгө нэрээр байршуулсан байна. Иймээс дараагийн аудитаар уг барьцаа хөрөнгийн баримт материалын бүрдүүлэлт, зарцуулалтыг шалгах нь зүйтэй юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 12,294.3 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,088.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 9,491.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 1,714.8 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. ЗДТГ нь нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлын батлагдсан төсвөөс 968.0 мянган төгрөгийн үнэ бүхий биеийн тамирын хувцас худалдан авсан, албан томилолтын зардлаас хувцасны хэмжээ өгөхөд 120.0 мянган төгрөгийг зарцуулсан зэргээр нийт **1,088.0** мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бусаар зарцуулсан хөрөнгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага

Сумын ЗДТГ :

1. Төсвийг зохистой удирдаж, төлбөр, тооцоог тухай бүр хянаж баталгаажуулаагүйн улмаас НДШ-ийн **4,778.1** мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “*Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж өр төлбөр үүсгэлгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

2. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүй төлбөрийн цахим баримтаар баталгаажаагүй **2738.7** мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь : МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

ИТХ:

1. ИТХ нь ГХУС арга хэмжээний зардлаас зөвлөлийн хурлын болон Засаг даргын захирамж, шийдвэргүйгээр **894.8** мянган төгрөгийн хяналтын камер худалдан авсан, **1,080.0** мянган төгрөгийн шатаахууныг сумын цагдаагийн өдөр тутмын үйл ажиллагаанд зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Хууль зүйн сайд, Сангийн сайдын 1998 оны 88/152 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам”-ын 2.7 дахь “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан тусгай дансанд төвлөрүүлсэн хөрөнгийг сум, дүүргийн Зөвлөлийн шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар дараах зориулалтаар зарцуулна”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан олгосон хөрөнгийг зориулалт бус зүйлд зарцуулах,...ыг хориглоно.” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ГХУС арга хэмжээний зардлыг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэх.

5.3 Зөвлөмж

1. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт: ХХС-аас 2013-2014 онуудад олгосон зээлийн хүүг сумын ИТХ-аар жилийн 1 хувиар тогтоосон байтал зээлийн бүртгэлийн программд тухайн онуудад 3 хувиар тооцон бүртгэснээс хүүгийн авлагын эхний үлдэгдэл нь санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлээс 1,714.8 мянган төгрөгөөр илүү бүртгэгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн байна

1.2 Өгсөн зөвлөмж: Иймд 2023 оны эхний хагас жилд багтаан зээлийн бүртгэлийн программд залруулга хийж санхүүгийн тайланд үнэн зөв тусгах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ЗДТГ	3	8,604.8	1	1,088.0	2	7,516.8						
ИТХ	1	1,974.8			1	1,974.8						
Хоршоог хөгжүүлэх сан	1	1,714.8					1	1,714.8				
Дүн	5	12,294.4	1	1,088.0	3	9,491.6	1	1,714.8				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ЗДТГ	3	1,941.9			2	1,941.9	1	
ИТХ								
Дүн	3	1,941.9			2	1,941.9	1	